



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.03 № 03/486

танай _____-ны № _____-т

Тодруулга авах тухай

Тус газраас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зарласан НХААГ/20240103244 дугаартай Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайжруулсан шахмал түлш тээвэрлэх-1 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг сонирхогч этгээдүүдээс тодруулга ирсэн байна. Үүнд:

ТШЗ 19.2-т 1.Ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарийг Таван толгой түлш ХХК, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газартай зөвшилцөн баталгаажуулан ирүүлнэ. (ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно) гэж заасан байна.

1. Тус ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарийг "Таван толгой түлш" ХХК, Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар аль аль нь гаргах, баталгаажуулах боломжгүй гэсэн хариу өгч байгаа тул тус заалтад хариу тайлбар тодруулга өгнө үү.
2. Ажлын даалгавар нь тодорхой бус байгаа бөгөөд үйлдвэрлэлийн хүчин чадал болон үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл болон хэдэн борлуулалтын цэгт тээвэрлэлтийн хийх талаарх мэдээлэл дээр тайлбар тодруулга өгнө үү. гэсэн байна.

Иймд дээрх тодруулгуудад 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор хариу тайлбар ирүүлж бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Сонирхогч этгээдүүдийн Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) – ээр ирүүлсэн тодруулгуудыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.